



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/227

Арвайхээр

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/788 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журмыг шинэчлэн батлах тухай” журмын 2.3, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд олон жил идэвх санаачилгатай ажилласан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, доктор, профессор Сүрэнжидийн Сээсрэгдоржийг Богд хаант Монгол Улсын анхны Ерөнхий сайд агсан Т.Намнансүрэнгийн нэрэмжит “Төрийн шилдэг түшээ” тэмдгээр мөн аймаг орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, салбар салбартаа амжилт гарган ажиллаж буй 11 иргэнийг “Аймгийн Засаг даргын жуух бичиг”-ээр, 3 иргэнийг аймгийн “Засаг даргын Тамгын газрын жуух бичиг”-ээр шагнаж, нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Шагналд дагалдах “Төрийн шилдэг түшээ” 200,000 (хоёр зуун мянга), аймгийн Засаг даргын жуух бичиг тус бүр 30,000 (гучин мянга), нийт 11 иргэнд 330,000 (гурван зуун гучин мянга) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын жуух бичиг тус бүр 20,000 (хорин мянга), нийт 3 иргэнд 60,000 (жаран мянга) төгрөг, бүгд 590,000 (таван зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0489

Аймгийн Засаг даргын 2022 оны
 05 дугаар сарын 03-ны өдрийн
 0000 дугаар захирамжийн
 хавсралт

ШАГНАЛ ОЛГОХ ИРГЭДИЙН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Дагалдах мөнгөн шагнал (төгрөг)
Нэг. "Төрийн шилдэг түшээ тэмдэг"-ээр			
1.	С.Сээсрэгдорж	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, доктор, профессор	200,000
Хоёр. "Аймгийн Засаг даргын жуух бичиг"-ээр			
1.	Ц.Лхагвадулам	Арвайхээр сумын өндөр настан	30,000
2.	С.Цэвэлням	Арвайхээр сумын өндөр настан	30,000
3.	Г.Өлзийсайхан	Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн сувилагч	30,000
4.	Ч.Цэрэндулам	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн дайчилгааны нууцын хэрэг хөтлөгч ахлах ахлагч	30,000
5.	Д.Хэнмэдэхүй	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн танкийн батальоны мотобуудлагын ротын механик жолооч, ахлагч	30,000
6.	Ц.Пүрэвдулам	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	30,000
7.	Д.Ганбаатар	Аймгийн Хөгжимт драмын театрын Уртын дуучин	30,000
8.	М.Ариунтуяа	Матрикс салоны үсчин	30,000
9.	Т.Гэрэлтогтох	Сант сумын малчин	30,000
10.	Ц.Бямбацогт	Сант сумын малчин	30,000
11.	Н.Отгонбаяр	Сант сумын малчин	30,000
Гурав. "Аймгийн Засаг даргын Тамгын газрын жуух бичиг"-ээр			
1.	Д.Батмэнд	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн танкийн сумлагч, ахлагч	20,000
2.	Б.Эрдэнэсайхан	Сант сумын малчин	20,000
3.	Я.Баянжаргал	Сант сумын малчин	20,000